


Хүүхдэд зориулсан Библи  
танилцуулж байна

## Үрэлгэн хүү



**Зохиогч: Edward Hughes**

**Зураглаач: Alastair Paterson; Lazarus**

**Найруулсан: Ruth Klassen; Sarah S.**

**Орчуулсан: Damdin Norolsuren**

**Бүтээсэн: Bible for Children**  
**[www.M1914.org](http://www.M1914.org)**

**©2020 Bible for Children, Inc.**

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах  
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



Есүс хүмүүст  
Бурханы  
уучлалын  
талаар  
ярихыг  
хүсжээ.



**Гэвч Иудейн  
удирдагчид  
түүнийг  
нүгэлтнүүдтэй  
нөхөрлөлөө  
хэмээн  
буруушаав.**



Гэтэл Есүс тэдэнд  
нүгэлтнүүд гэмээ  
гэмшихэд Бурхан  
хэрхэн баярладаг  
тухай гурван  
түүх ярьж  
өгчээ.




**Эхний түүх  
нь зуун  
хоньтой**

**хүний тухай  
юм. Түүний  
нэг хонь нь алга  
болжээ.**



**Хоньчин ерэн  
есөн хонио  
үлдээгээд**

**алга болсон  
нэг хонио  
хайхаар  
явжээ.**





**Хоньчин алга  
болсон хонио олох  
хүртэл түүнийг  
хайсаар байлаа.  
Тэгээд тэр  
түүнийг**

**олоод мөрөндөө  
тэгнэн баяртайгаар  
гэртээ ирэв.**







**Тэр найзуудаа  
дуудан "Надтай  
хамт баярлаач  
би алдсан хонио  
оллоо" гэв.**



**Есүс үүнтэй  
адилаар нэг  
гэмтэн  
гэмшихэд  
тэнгэрт маш  
их баяр хөөр  
болдог хэмээн  
тайлбарлав.**



**Гэмших гэдэг нь  
хийсэн буруу  
зүйлийнхээ  
төлөө гэмшиж  
дахин буруу  
зүйл хийхгүй  
байхын төлөө  
хичээхийг  
хэлнэ.**





**Есүс дахин  
ярьж нэгэн  
эмэгтэй  
байсан бөгөөд  
түүнд арван  
мөнгөн зоос  
байв.**





**Азгүй зүйл  
болж эмэгтэй  
нэг мөнгөн  
зоосоо алга  
болгожээ.**




**Тэр эмэгтэй гэрээ  
шүүрдэн шүүрдэн  
шүүрдэн хаа сайгүй  
хайлаа.**



Эцэст нь тэр алдсан  
зоосоо олов. Тэр маш  
баяр хөөртэй  
байв.



**Тэгээд тэр яасныг таа  
даа? Тийм ээ, тэр энэ  
тухай найз нартаа  
ярьсан  
юм.**







**Есүс "Нэг  
нүгэлтэн  
гэмшвэл  
Бурханы  
тэнгэр элч  
нарын  
оршихуйд  
баяр хөөр  
болдог" гэв.**



Есүсийн ярьсан гурав  
дахь түүх бол гунигтай  
түүх юм. Эцгийнхээ  
гэрийг орхин  
гарсан нэгэн  
хүүгийн  
тухай  
байлаа.




**Тэр хүү холын нэгэн оронд очин бүх мөнгөө дэмий үрж дуусжээ. Одоо тэр яах бол? Байдал бүр дордов.**




**Тэр газарт өлсгөлөн болжээ. Өнөөх  
хүү өлсгөлөнд нэрвэгдэн үхлийн  
ирмэг дээр  
иржээ.**




**Өлсөж үхэхгүйн тулд хүү гахай  
хооллодог ажил олжээ.**



**Тэр гахайн идэж байсан буурцгаар  
ходоодоо дүүргэхийг хүсэмжлэвч хэн  
ч түүнд юу ч өгсөнгүй.**



**Тийнхүү тэр ухаарав. Эцэст нь тэр  
"Би гэрлүүгээ буцаа, манай гэрийн  
зарц нар хүртэл цадталаа хоол иддэг  
шүү дээ" гэв.**



**Би босоод,  
эцэг уруугаа  
очъё.**








**Тэгээд түүнд "Аав аа,  
би таны өмнө нүгэл  
үйлдсэн. Би цаашид  
таны хүү гэгдэх  
нь зохисгүй, харин  
намайг хөлснийхөө  
нэг хүн  
болгооч  
гэж хэлье"**


**ГЭЖ БОДОВ.**




**Түүнийг гэрлүүгээ буцаж явахад  
эцэг нь холоос харав.**



**Эцэг нь буцан ирж байгаа хүүгээ  
хараад баяр хөөртэйгөөр гүйн  
очив. Тэр хүүгээ  
тэврэн аваад  
үнэсэв.**







**Хүү нь "Аав  
аа, таны  
өмнө нүгэл  
үйлдсэн. Би  
цаашид таны  
хүү гэгдэх нь  
зохисгүй"  
гэв.**



**Мөн тэр  
эцгийнхээ  
хөлсний  
хүмүүсийн нэг  
болохыг хүсч  
буйгаа хэлэв.**





**Харин эцэг  
нь боолууддаа  
"Хамгийн сайхан  
хувцас хурдан  
авчирч, түүнийг  
хувцасла. Гарт нь  
бөгж зүү, хөлд нь  
гутал өмсгө бас  
найрын ширээ  
бэлтгэ гэв."**



**Тэгээд энэ  
айл тэр орой  
том найр  
хийжээ.  
Учир нь  
алдагдсан  
хүү нь  
олдсон  
юм.**



**Есүс гэмшээд өөр уруу нь ирж байгаа  
хүнийг Бурхан  
хэрхэн хайрлаж  
хүлээн авдаг  
болохыг  
ойлгуулахын  
тулд энэ  
түүхийг  
ярьж  
өгчээ.**





# Үрэлгэн хүү

Бурханы үг Библиээс авсан түүх

Лук 15

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



**Төгсөв**



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг  
бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж  
хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж  
хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь  
үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир  
Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн  
өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг  
зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс  
дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та  
Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал  
гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр  
таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та  
түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.



Хэрвээ та энэ үнэнд итгэж  
байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй:  
Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон  
миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та  
амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж  
ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос  
эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр  
тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд  
дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө  
амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай  
ярилцаарай! Иохан 3:16

